

АГУУЛГА

ОРШИЛ	2
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Төслийн үйл ажиллагааны хураангуй	4
1.2.1. Уурхайн жилийн хүчин чадал	5
1.2.2. Уурхайн хүний нөөц, ажлын горим	5
1.2.3. Дэд бүтэц	5
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 14	
БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	16
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
5.1. Байгаль хамгаалах төлөвлөгөө	18
5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
5.1.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
5.1.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
5.1.4. Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөө	19
5.1.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	19
5.1.6. Түүх, соёлын өвийг хамгаалах, арга хэмжээний төлөвлөгөө	20
5.1.7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
5.1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
5.1.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
5.1.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	25
5.1.11. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	25
5.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал	25
ДҮГНЭЛТ	27
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	28

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1 Төслийн ерөнхий мэдээлэл	3
Хүснэгт № 2 Цагаан залаатын хэсгийн үйлдвэрлэлийн нөөц	4
Хүснэгт № 3 Төслийн нийт ажилчдын тоо, бүрэн хүчин чадлаар ажилласан тохиолдолд	5
Хүснэгт № 4. Уурхайн ажлын горим	5
Хүснэгт №5. Барилга, байгууламжийн мэдээлэл	5
Хүснэгт № 6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт № 7 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	19
Хүснэгт № 8 Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөөний зардал	19
Хүснэгт № 9 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
Хүснэгт № 10 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт № 11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	21
Хүснэгт № 12 ОХШХ-ийн мониторингийн цэгүүдийн координат	22
Хүснэгт № 13 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө	24
Хүснэгт № 14 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	25
Хүснэгт № 15 БОМТ-ний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	25
Хүснэгт № 16 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	25

ЗҮРГИЙН ЖАГСААЛТ

Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн сансрын байрзүйн зураг	3
Зураг № 2. Тээврийн замын ерөнхий маршрут	6
Зураг № 3. ОХШХ-ийн мониторингийн цэгүүд	23

ОРШИЛ

“Дорнын чулуулаг” ХХК-ийн Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.


2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 50,637.15 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт № 1 Төслийн ерөнхий мэдээлэл

№	Ерөнхий мэдээлэл	
1	Төслийн нэр	Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ил аргаар ашиглах
2	Ашигт малтмалын төрөл	Хүрэн нүүрс
3	Засаг захиргааны нэгж	Сүхбаатар аймаг, Сүхбаатар болон Асгат сумд
4	Төслийн хугацаа	Ордыг 20 жилийн хугацаанд ашиглана
5	Төсөл хэрэгжүүлэгч	Дорнын чулуулаг ХХК
6	Улсын бүртгэлийн дугаар	9011030019
7	Регистрийн дугаар	5070287
8	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Санктпетрбург төв, 220 тоот
9	Тусгай зөвшөөрөл	1,562.79 гектар талбай бүхий ашигт малтмалын MV-017551 тоот дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын газраас Дорнын чулуулаг ХХК-д 2044.06.09 дуустал хугацаагаар олгосон байна. 533.34 гектар талбай бүхий ашигт малтмалын MV-017432 тоот дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын газраас Дорнын чулуулаг ХХК-д 2043.12.04 дуустал хугацаагаар олгосон байна. 7,158.09 гектар талбай бүхий ашигт малтмалын MV-017433 тоот дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын газраас Дорнын чулуулаг ХХК-д 2043.12.06 дуустал хугацаагаар олгосон байна.



Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн сансрын байрзүйн зураг

1.2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Уурхайн одоогийн байдал

“Дорнын чулуулаг” ХХК нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар геологийн боломжтой (С) зэрэглэлийн нөөцөөс 400.86 мян.тн нүүрс олборлосон байна. Анх батлагдсан болон үлдэгдэл геологийн нөөцийг доорх хүснэгтэд харуулав. Мөн нүүрсний түр овоолгын талбайд 94.86 мян.тн нүүрсний үлдэгдэл нөөцтэй байна.

Ашигт малтмалын нөөц

Ордын баттай (А), бодитой (В) зэрэглэлийн нөөцөд тулгуурлан боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг ил уурхайн хүрээ хязгаараар өртүүлэн ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотгол-1-ийг боловсруулсан ба хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай үйлдвэрлэлийн нөөцийг батлагдсан (А'), магадаласан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт (А'), (В') үйлдвэрлэлийн нөөц нь 89,930.26 мян.тн нүүрс, 248,838.54 мян.м³ хөрс болж байна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 2.77 м³/тн болж байна.

Хүснэгт № 2 Цагаан залаатын хэсгийн үйлдвэрлэлийн нөөц

Үйлдвэрлэлийн нөөц	Хаягдал нүүрсний хэмжээ		Бохирдуулагч чулуулгийн хэмжээ	Тэсэлгээний үед бохирдох чулуулгийн хэмжээ	Нийт бохирдол	Бохирдлын хувь	Хуулах	Нүүрсний нөөц
	мян.тн	%	мян.тн	мян.тн	мян.тн	%		мян.тн
Ордын хэмжээнд А зэрэглэлээр	71.68	0.53	53.33	67.77	121.10	0.89	248,835.54	13,603.74
Ордын хэмжээнд В зэрэглэлээр	390.02	0.97	289.94	201.01	490.95	1.22		40,302.38
Ордын хэмжээнд С зэрэглэлээр	378.05	1.05	281.38	199.88	461.09	1.28		36,024.13
Ордын хэмжээнд А+В+С зэрэглэлээр	839.75	0.94	624.65	468.65	1,073.13	1.20		89,930.26
Нүүрсний овоолго								94.86

Хөрөнгө оруулалтын хэмжээ

Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ашиглах уурхайг байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ 334.16 тэрбум төгрөг байна. Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 248,835.54 мян.м³ хөрс хуулалтын ажлыг хийж, 89,930.26 мян.тн нүүрсийг олборлоно. Нэг тн нүүрсийг 65,000 төгрөгөөр борлуулахаар тооцсон.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт

Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 248,835.54 мян.м³ хөрс хуулалтын ажлыг хийж, 89,930.26 мян.тн нүүрсийг олборлоно. Нэг тн нүүрсийг 65,000 төгрөгөөр борлуулахаар тооцсон.

Орд ашиглалтын 20 жилийн хугацаанд нийт 5,845.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 1,969.3 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 2,909.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Ашиглалтын хугацаанд нийт 3,211.7 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болно. 10 хувийн хорогдуулалтын норм тооцсон төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ 905.6 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 36% байна, хөрөнгө оруулалтаа 3.9 жилд нөхнө.

1.2.1. Уурхайн жилийн хүчин чадал

Ил уурхайн жилийн хүчин чадал эхний жилд 1 сая.тн, 2 дахь жилд 2 сая.тн, 3 болон 4 дэх жилд 3 сая.тн, 5 дахь жилээс 5 сая.тн нүүрс олборлоно.

Ашиглалтын 5 дахь жилээс уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж жилийн хүчин чадал 5 сая.тн болох ба орд ашиглалтын нийт хугацаа 20 жил байна.

1.2.2. Уурхайн хүний нөөц, ажлын горим

Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ашиглах төслийг хэрэгжүүлснээр 128-303 хүний ажлын байр бий болно. Хоногт 2 ээлж, ээлжид 12 цагаар ажиллана.

Хүснэгт № 3 Төслийн нийт ажилчдын тоо, бүрэн хүчин чадлаар ажилласан тохиолдолд

№	Ашиглалтын жил	Эхний жилд
1	Төв оффис	7
2	Уулын хэсэг	72
3	Засвар механик	12
4	Аж ахуй, үйлчилгээ	37
	Нийт	128

Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу жилд амрах баяр ёслолын хоног мөн цаг агаарын хүндрэлээс шалтгаалан ил уурхайн үйл ажиллагаа зогсож болзошгүй хугацааг уурхайн ажлын горимд оруулан тооцлоо.

Хүснэгт № 4. Уурхайн ажлын горим

Хоног, зориулалт	Сар, хоног												Жилд
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Хуанлийн		28	31	30	31	30	31	31	30	31	30	15	318
Баяр ёслол		5	0	0	0	0	5	0	0	0	0		10
Ажлын өдөр		23	31	30	31	30	26	31	30	31	30	15	308

1.2.3. Дэд бүтэц

Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ашиглахад шаардлагатай дэд бүтэц болох уурхайн цахилгаан хангамж, ус хангамж, дулаан хангамж, хотхоны барилга болон зам, харилцаа холбоо, бусад тоног төхөөрөмжүүд бэлэн байгаа болно.

Хүснэгт №5. Барилга, байгууламжийн мэдээлэл

№	Барилгын нэр	Х.нэгж	Хэмжээ	Тайлбар
1	Уурхайн удирдлагын байр	м ²	50	сэндвич
2	Ажилчдын сууц	м ²	400	сэндвич
3	Цайны газар	м ²	180	сэндвич
4	Халуун ус болон угаалга	м ²	30	сэндвич
5	Тэсрэх бодис, хэрэгслийн агуулах	ш	2	40 тн контейнер
6	Лаборатори	м ²	50	сэндвич
7	Сэлбэгийн агуулах	ш	2	40 тн контейнер
8	Засварын талбай	м ²	200	шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна
9	Түлшний ёмкость	ш	3	150 тн ёмкость
10	Гаалийн талбайн байр	м ²	40	сэндвич
11	Гаалийн талбайн хашаа	м	800	төмөр хийцлэл бүхий
12	Уурхайн удирдлагын байр	м ²	50	сэндвич

Дулаан хангамж: Уурхайн барилга, байгууламжийн хувьд сэндвичэн хийцлэлтэй байгаа бөгөөд сэрүүний улиралд цахилгаанаар халаана.


Цахилгаан хангамж: Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийн уурхайн цахилгаан хэрэглэгчдийг дизель генератораар цахилгаан эрчим хүчээр хангахаар

төлөвлөлөө. Компанид одоо байгаа НУW-200 T5 маркийн 160/176 кВт-ын 1 ширхэг дизель генератор нь тооцоолсон хүчин чадлыг хангахад хүрэлцээтэй байна.

Усан хангамж: Ил уурхайн ашиглалтын үед усны хэрэгцээг гүний худаг болон ил уурхайн шүүрлийн усаар хангахаар төлөвлөсөн.

Уурхайн зам: Цагаан залаатын хүрэн нүүрсний ил уурхай нь олборлосон нүүрсээ Бичигтийн боомтоор дамжуулан БНХАУ-д борлуулна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 13-ний өдрийн 195 дугаар тушаалын дагуу Ерөөлтийн нүүрсний уурхайгаас Бичигтийн боомт чиглэлд хатуу хучилттай тусгай зориулалтын 197.5 км авто замын ажлыг барьж гүйцэтгэнэ.



Зураг № 2. Тээврийн замын ерөнхий марируут

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүйн нөхцөл:

Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат сумд нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Монголын Дорнод талын их мужийн Халхын дундад ба Дарьгангын талархаг дэд мужийн Дорнод хотгорын тойрогт багтана.

Энэ мужийн онцлог нь ухаа гүвээт, тэгш талуудтай. Дундаж өндөр нь 600-900 м, хуурай хээрийн ландшафттай. Хур тунадас 200-250 мм, зундаа 25-30 °С, өвөлдөө (-25) – (-30) °С хүрнэ. Ус хамгийн багатай. Хялганат хээр зонхилдог

Байгалийн бүс бүслүүр:

Судалгааны талбай нь байгалийн бүс бүслүүрийн хувьд А.А.Юнатовын ангиллаар хээрийн бүслүүрт хамаарна. Хээрийн бүс нь нийт нутгийн 25 %-ийг эзэлж, Хангай-Хэнтийн уулархаг их нутгийг хүрээлэн, нутгийн хойд-төв хэсгээр төвлөрнө.

Газрын гадаргыг голлон хэлбэр нь толгодорхог тал бөгөөд зүүн тийшлэх тутам толгод нь намхан болж, холдсоор зүүн талдаа дов толгодгүй тэгш тал болно. Хуурайдуу сэрүүн зунтай, хахир өвөлтэй. 1 дүгээр сарын дундаж температур -20.1 °С, 7 дугаар сарын дундаж температур 21.6 °С жилийн дундаж хурд салхины 4 м/с жилийн хур тунадасны нийлбэр 180 мм байна.

Гадаргын болон газрын доорх ус

Гадаргын ус: Ус зүйн мужлалаар Төв Азийн гадагш урсгалгүй ай сав, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарна.

Монгол орны төв ба дундад халхын тал, өмнөд болон зүүн өмнөд говийн бүсийн хур тунадас багатай нутаг дэвсгэрт хамаарагддаг. Газрын гадаргын хувьд баруун хагас нь уулархаг бөгөөд нутгийн ихэнх хэсэг ухаа гүвээт тал, цав толгод, хотгор нам газар болно.

Энэ бүс нутагт гадаргын ус нэн ховор. Сав газрын баруун хойд хэсгээр (Өвөрхангай аймаг) Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамрагдах гол цөөн тоотой бий. Харин говийн бүсэд түр зуурын уруйн ус урсах хуурай сайрууд маш түгээмэл ажиглагддаг.

Тус сав газар нь говийн бүсэд хамаардаг, говь хээр хосолсон эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41 хэм хүртэл халж, өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг. Салхины дундаж хурд 4.2-4.6 м/сек, зарим үед 35 м/сек хүртэл ширүүсдэг, салхи ихтэй, өдөр шөнийн агаарын хэмийн ялгаа их нутаг юм.

Сав газар нь далайн түвшнээс дээш дунджаар 1,267 метр өргөгдсөн, баруунаас зүүн зах хүртэл 858 км урт, хойноос урагш 424 км өргөн, 2,700 км хилийн цэсийн урттай нутаг хамаарах ба монгол орны бусад сав газруудаас талбайн хэмжээгээрээ 2 дугаарт ордог.

Төслийн талбайг ойр орчмын усны сүлжээний зурагтай давхцуулан зураглахад талбайн ойр орчимд гадаргын усны эх үүсвэр байхгүй бөгөөд Монгол орны гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалгүй байна.

Газрын доорх ус: Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат сумдын нутаг нь Монгол орны гүний усны тэжээгдлийн мужлалаар газрын доорх усны түвшин жилд 5 мм-ээс бага тэжээгдэлтэй мужид хамаарч байна.

Гидрогеологийн судалгаа: Сүхбаатар аймгийн Сүхбаатар болон Асгат сумдын нутаг Ерөөлтийн бүлэг ордын талбайд 2011 онд төлөвлөсөн гидрогеологийн судалгааны ажлыг гидрогеологич Ж.Дашдондов, Я.Бямбадорж нар 2011 оны 07 дугаар сарын 25-наас 2011 оны 10 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэжээ. 2025 оны 09 сард “Орд-Ус” ХХК-ийн гидрогеологич Ж.Дашдондов гидрогеологийн судалгааг дахин хийж гүйцэтгэжээ.

Ерөөлтийн ордын талбайд гидрогеологийн ажиглалтын ЕЦ-01a, ЕЦ-01b, ЕЦ-02a, ЕЦ-02b-р цооног 120-130 м-ийн гүнтэй өрөмдлөгийн ажил хийж цооногуудад гидрогеологийн туршилт-шавхалтын ажлуудыг зохих шаардлагуудын дагуу хийж гүйцэтгэв.

Ерөөлтийн талбай түүний ойр орчмын газрын гадаргуу хэрчигдэлд бага орсон ба гадаргуугийн хотгор, гүдгэрийн эрс ялгаа байхгүй жижиг дов, ухаа, гүвээ тохиолдоно. Төлөвлөж байгаа ил уурхай байгуулах ойр орчимд гол, мөрөн урсгал ус, нуур, цөөрөм зэрэг тогтмол ус байхгүй. Хүчтэй усжилт бүхий тектоникийн том хагарал, тохрол, өргөгдөл, суулт, шохойн чулууны карст, олон жилийн цэвдэг чулуулгийн тархалт тохиолдохгүй юм.

Ул суурийн хурдас нь шаварлаг хурдас тухайлбал цайвар цагаан өнгийн алевролит, алевро-элсэнчулуу, шаварлаг материалаар цементлэгдсэн конгломератаас тогтох ба усжилт бага байдаг онцлогтой. Ордын гидрогеологийн нөхцөлийн хувьд дээрх хүчин зүйлүүд “энгийн” нөхцөлтэй ангилалд оруулах боломжийг бүрдүүлж байна.

Худгийн уснаас усны 1 сорьц авч шинжлүүлэхэд Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Унд ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS:0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Ерөөлтийн ил уурхайн шүүрлийн уснаас дээж авч шинжлүүлэхэд Тунгалаг, цайвар сааралдуу өнгөтэй, үнэргүй, бага зэрэг тунадастай шинж чанартай, Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу, хатуулаг дотроо магнийн ион зонхилсон, булингартай ус байна. Уг усанд давсны нөлөөлөл их, усалгааны коэффициент $K_a=6.14$ байгаа тул ногоон байгууламжийн усалгаанд хэрэглэхэд төдийлөн тохиромжтой биш байна.

Хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжих Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат сумдын нутаг нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар Хангайн их муж, Монгол дорнод дэд мужийн Баруун-Уртын тойрогт хамаарагдана.

Судалгааны талбай нь хөрс-газарзүйн мужлалаар Хотгорын бүсшилтэй нутагт хамаарна. Энд хур чийг бага, хөрсний органик үлдэгдлийн хэмжээ мөн бага ургамал тачир сийрэг. Тус талбайн байгалийн бодит байдал нь талбайн баруун хойд хэсэг нь ДТД 1,000 м өндөр, зүүн урд талд ДТД 1,100 м өндөр буюу баруун хойш хэвгийлэлттэй, зүүн талаар намхан толгод ба гүвээ гүдгэр газартай, баруун тал нь хотгордуу тэгш рельефтэй нутаг байна. Тэнд ерөнхийдөө талын хүрэн хөрс тогтворжсон байна.

Том талбай учраас талбайн урд ба зүүн, зүүн хойт хэсгээр карбонаттай шавранцар хүрэн хөрс тархсан байхад талбайн баруун урд, баруун болон баруун хойт ба хойт хэсгээр карбонатгүй элсэнцэр хүрэн хөрс тархжээ.

Хээрийн судалгаагаар 4 цэгт хөрсний үндсэн зүсэлт хийж агрохимийн шинжилгээ, нэг цэгээс хүнд металл болон эрүүл ахуйн дээж авч нийт 15 үзүүлэлтээр задлан шинжлүүлсэн.

Байгалийн тогтцоор байгаа карбонаттай хөнгөн шавранцар хүрэн хөрсний 15 см зузаантай А давхаргад ялзмагийн дундаж хэмжээ 2.24 %, Вк давхаргад 0.97 %, ВСк давхаргад 0.51 % байна. Тус хөрсний үржил шимт давхаргын зузаан 15 см. Энэхүү үзүүлэлт нь Монголын хээрийн бүсийн тал газрын дээр карбонаттай хүрэн хөрсний дундаж үзүүлэлттэй дүйцэж байна. Уусмалын орчин (рН) 0-45 см-ийн гүнд 7.7-8.3 буюу “дунд” шүтлэг орчинтой, давсжилт “А” давхаргын доод хэсгээс 13-41 см-ын гүнээс илэрч байна, Солилцох сууриудын нийлбэр А давхаргад 19-20 мг-экв/100 г байна. Шим тэжээлийн бодис болох хөдөлгөөнт фосфор 0.9 мг-экв/100г, калийн агууламж 12 мг-экв/100г байгаа нь

агууламжийн хэмжээ “багаас дунд” байна. Механик бүрэлдэхүүний хувьд “А” давхарга хөнгөн шавранцар (23.9 %), харин Вк ба ВСк давхаргад физик шавар 25.5-29.7 % байж механик бүрэлдэхүүн хөнгөн шавранцрын төрөл орж байна.

Карбонатгүй элсэрхэг хүрэн хөрсний 30 см зузаантай А давхаргад ялзмагийн дундаж хэмжээ 1.57 % байж карбонаттай хөрснийхөөс 1.4 дахин бага байна. Тус хөрсний үржил шимт давхаргын зузаан 30 см байгаа нь карбонаттай хөрснийхөөс 2 дахин зузаан байна. Уусмалын орчин (рН) 0-60 см-ийн гүнд 7.4-7.6 буюу “сул” шүтлэг орчинтой, давсжилт бүх давхаргад байхгүй онцлогтой. Солилцох сууриудын нийлбэр А давхаргад 10 мг-экв/100 г байна. Шим тэжээлийн бодис болох хөдөлгөөнт фосфор 1.1 мг-экв/100 г, калийн агууламж 8 мг-экв/100 г байгаа нь агууламжийн хэмжээ “бага” байна. Механик бүрэлдэхүүний хувьд “А” давхарга элсэнцэр (12.8-13.4 %), харин Вк ба ВСк давхаргад физик шавар 13.1-19.2 % байж механик бүрэлдэхүүн элсэнцэр байж карбонаттай хүрэн хөрснийхөөс шаврын хэмжээ 2 дахин их байна.

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А.Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход нийт зүсэлтийн 20 см-ээс их гүнээс авсан дээжүүд нь элсэрхэг, нийт зүсэлтийн өнгөн хөрсний дээж нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсний дээжид хийгдсэн хүнд металлын шинжилгээний үр дүнг (MNS 5850:2019) Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад хүлцэх болон аюултай, хортой агууламжаас даваагүй байна.

Ургамлан нөмрөг

Төслийн талбай нь Ургамал-газар зүйн мужлалын хувьд Евро-Азийн хээрийн их муж, Төв Азийн Мөнххааны тойрогт, Академич Н.Өлзийхутагийн ангиллаар Дорнод Монголын хуурай хээрийн тойрогт хамаарна.

Төслийн талбайн баруун болон төв хэсгээр Хялгана-хазаарт бэлчээрийн хэв шинж тархсан, талбайн баруун урд хэсгээр Хялгана-үетэнт бэлчээрийн хэв шинж тархсан бол талбайн зүүн хэсгээр Хялгана-дааган сүүлт бэлчээрийн хэв шинж тус тус зонхилон тарсан байна.

Судалгааны талбайн нь хээрийн бэлчээр бөгөөд 3 бүлгэмдэлд 13 овгийн 29 төрлийн нийт 33 зүйл ургамал бүртгэгдсэн. Энэхүү ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд Сөөг-2 (6 %), сөөгөнцөрлөг-3 (9 %), олон наст өвс-23 (70 %), ганц ба хоёр наст-5 (15 %) зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.

Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 57 %, зүйлийн бүрэлдэхүүн харьцангуй сайн, 1м² талбайд 24 зүйл ургамал тархаж байна. Бэлчээрийн зонхилогч зүйл нь *Stipa krylovii*-крыловийн Хялгана, дэд зонхилогч зүйл нь *Cleistogenes squarrosa*-дэрвээн Хазаар өвс, *Koeleria macrantha*-том цэцэгт Дааган сүүл зэрэг үетэн ургамлууд бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ сибирь Үрээн сүүл, *Allium bidentatum* шүдлэг Сонгино, амманы Сэдэргэнэ зэрэг ургамлууд зонхилон ургасан. Энэхүү бүлгэмдлийн өнөөгийн төлөв байдал дунд зэрэг доройтолд орсны улмаас уг бүлгэмдэл флорын баялгаараа ядмаг болсон байна. Бэлчээрийн төрлийн дундаж өндөр-32 см, Зонхилогч болон дэд зонхилогч зүйл ургамлууд хөгжлийн үе шатаа бүрэн дамжин өнгөрүүлсэн байна.

Тус төслийн талбайд ховор ургамал 3 таарсан бөгөөд нэн ховор ургамал тааралдаагүй болно. Ерөөлтийн ордын ашиглалтад өртөөгүй газар нь сум орон нутгийн газрын нэгдмэл сангийн ангиллаар ХАА-н бэлчээрийн газарт хамаарна.

Төслийн талбай орчмын 2021-2025 оны ургамлын индексийн утгыг ургамлын мониторингийн судалгаа хийсэн цэгүүдийг оруулан жил жилийн ялгарлыг харахад 2021-

2023 онуудад судалгааны талбай орчим индексийн утгаар бут сөөг ихтэй, үржил шимгүй газар зонхилж байсан бол 2024-2025 онуудад индексийн утгаар бут сөөг, сийрэг, өтгөн-ургамалтай болсон харагдаж байна. Энэ нь байгаль цаг уурын нөхцөлөөс хамаарсан мөн малын тоо толгой багассантай холбоотой өөрчлөлт гэж үзэж байна.

Судалгаа явуулсан талбайд хүрэн, элсэрхэг хүрэн хөрстэй, өвс ургамал элбэгтэй боловч ажилчдын хотхон орчмоор хөл газрын ургамал тархсан байна.

Амьтны аймаг

Сүхбаатар аймагт орших Ерөөлтийн хүрэн нүүрсний орд нь амьтны газарзүйн мужлалаар (Банников, 1954) Монгол Дагуурын тойрогт хамаарна. Харин байгалийн бүс, бүслүүрийн хувьд хээрийн бүсэд оршино (Батчулуун, 2020). Төв Халхын хээр, Дорнод Монголын мужийн завсрын байрлалтай. (Цэгмид, 1969). Уг талбай нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт хамрагдаж байгаа намхан толгод бүхий тал хөндий газар, ДТД 1035-1090 м өндөртэй урдаасаа хойш намссан аядуу налуу бүхий нутаг юм.

Хөхтөн амьтдын төлөв байдал: Энд бид 7 багийн 30 зүйл хөхтөн тохиолдох боломжтой гэж үзэв. Үүнийг ангилал зүйн багаар задлан үзвэл: зараа 1, шавж идэштэн 2, гар далавчтан 2, туулай 2, мэрэгч 13, мах идэштэн 9, туруутан 1 зүйл тус тус байна.

Шувуудын төлөв байдал: Талбай орчимд 11 баг 76 зүйл шувуу ажиглагдсанаас нүүдлийн өндөглөдөг 13, дайрч өнгөрдөг 1, суурин 30, хагас суурин 2, нийт 76 зүйл байв. Нэн ховор, ховор амьтны жагсаалтад орсон нийт 8 зүйл байгаагаас Монголын улаан номд (Шийрэвдамба, 1997) бүртгэгдсэн 6 зүйл байна. Энд шилийн сар (*Buteo hemilasius*), талын бүргэд (*Aquila rapax*), Дорнодын хиазат (*Charadrius veredus*), монгол болжмор (*Melanocorypha mongolica*) зэрэг жинхэнэ тал хээрийн шувууд байхаас гадна зарим ус, намаг, ойн шувуу тархсан. Мөн усны бух шувуу (*Botaurus stellaris*), хошуу галуу (*Anser cygnoides*), амарын шонхор (*Falco amurensis*), азийн цууцаль (*Limnodromus semipalmatus*) зэрэг ховор шувууд нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг.

Хоёр нутагтан, мөлхөгчид: Монгол оронд тэмдэглэсэн 24 зүйл хоёр нутагтан, мөлхөгч амьтад байдгаас (Мөнхбаяр et al., 2023) тус бүс нутагт 4 зүйл тархсан. Үүнд: монгол бах (*Bufo raddei*), монгол гүрвэл (*Eremias argus*), рашааны могой (*Elaphe dione*), бамбай хоншоорт могой (*Gloydius halus*) болно. Эдгээр нь цөм бүс нутгийн хэмжээнд анхааралд өртөхөөргүй гэсэн ангилалд багтана (Тэрбиш et al., 2006). Харин олон улсын түвшинд үнэлээгүй болно.

Түүх соёлын дурсгал

Дорнын чулуулаг ХХК нь 2012 онд төсөл хэрэгжих талбайд “Монгол улсын шинжлэх ухааны академи Палеонтологийн төв”-тэй гэрээ байгуулсны үндсэн дээр палеонтологийн судалгааг хийлгүүлсэн байна. Палеонтологийн судалгаа, ажиглалтын үр дүнд “Ерөөлт” нэртэй талбайд эртний амьтан, ургамлын үлдэгдэл илрээгүй байна.

Цаашид уурхайн ашиглалтын үед Археологийн болон палеонтологийн ховор түүх соёлын дурсгалт олдвор илэрсэн тохиолдолд ШУА-ийн “Палеонтологийн төв”-д хандаж, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу авран хамгаалах малтлага хийлгэх ажил хийлгэхийг санал болгосон байна.

Хайгуул, судалгаа хийсэн талбайд 3 хэсэг газарт дурсгалууд илэрсэн байна. Тэдгээр нь Дорнын чулуулаг ХХК-ийн MV-017433 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас гадна байх бөгөөд хамгийн ойрдоо 1.5 км зайтай байгааг харуулсан.

1-р хэсэг газрын дурсгал буй талбай нь далайн түвшнээс дээш 1,019 метр өндөрт оршиж байна. Уг дурсгал байгаа талбайн хэмжээ нь 50 м² буюу 0.25 га талбайг эзэлж байна. Энэхүү талбайд дөрвөлжин булш 2, хэлбэр хэмжээ он цаг тодорхойгүй 8 булш байна.

2-р хэсэг газрын дурсгал буй талбай нь далайн түвшнээс дээш 1,020 метр өндөрт оршиж байна. Уг дурсгал байгаа талбайн хэмжээ нь 170*375 м² буюу 6.35 га талбайг эзэлж байна. Энэхүү талбайд хэлбэр хэмжээ он цаг тодорхойгүй 1 булш байна.

3-р хэсэг газрын дурсгал буй талбай нь далайн түвшнээс дээш 1,030 метр өндөрт оршиж байна. Уг дурсгал байгаа талбайн хэмжээ нь 50 м² буюу 0.25 га талбайг эзэлж байна. Энэхүү талбайд хэлбэр хэмжээ он цаг тодорхойгүй 1 булш байна.

Судалгаа хийсэн нийт талбайн хэмжээнд 3 хэсэг газарт нийт 3 овоо, 12 булш байна. Иймд уг 3 хэсэг газарт суваг шуудуу, нүх ухах, том техник дээгүүр нь явах зэргээр хөрсийг гэмтээж болохгүй. Хэрэв дээрх үйлдлүүдийг хийвэл уг дурсгалууд гэмтэх эвдрэх аюул бий болно. Дээр дурдсанаас бусад археологийн дурсгал илрээгүй талбайд геологийн хайгуулын үйл ажиллагаа явуулахад түүх соёлын дурсгалын талаас харшлах зүйлгүй болно гэсэн байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт

Цагаан залаатын хүрэн нүүрсний уурхайн талбайгаас газарзүйн хувьд хамгийн ойр байрлах Улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь “Дарханхаан уул” Дурсгалт газар (ДГ) 30 км зайтай оршдог.

Дарханхаан уулыг 2012 оны УИХ-ын 57-р тогтоолоор Улсын тусгай хамгаалалтад авсан бөгөөд 1,464.98 га талбайтай байна.

Дарханхаан уул нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын төвөөс зүүн тийш 8 км орших эртний хөрзөн чулуу, элсэн чулуу, боржингоос тогтсон уул, хамгийн өндөр цэг нь 1,056 м. Дархан уулын урд дор нь Шаварт нуур оршино. Нутгийн ардууд Их Цагаан нуур хэмээн нэрлэдэг байна. Дарханхаан уул нь байгалийн тогтцын хувьд өвөрмөц байхын хамт олон төрөл зүйлийн амьтан ургамлаар баян нутаг юм. Дарханхаан уулыг нутгийн иргэд тахин шүтэж Дархан цолт Баянмөнх хаан уул гэж хүндэтгэн нэрлэж хайрлан хамгаалсаар иржээ. Энэхүү уулыг 1863 оны үед манжийн хааны зарлигаар дархлан хамгаалж байсан түүхтэй. (<https://eic.mn/spa/>)

Төсөл хэрэгжих аймгийн нийгмийн байдал:

Цагаан залаатын хүрэн нүүрсний уурхайн төсөл нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ланз 4-р баг болон Асгат сумын Өлзийт 1-р багийн нутагт хэрэгжинэ.

Сүхбаатар аймаг нь 13 сумын 67 багтай. Аймгийн төв нь Баруун-Урт хот. Аймгийн нийт хилийн урт 1,340 км бөгөөд урд талаараа БНХАУ-тай 485 км, баруун талаараа Дорноговь аймагтай 165 км, хойд талаараа Хэнтий аймагтай 260 км, зүүн хойд талаараа Дорнод аймагтай 430 км газраар тус тус хиллэнэ.

Нийт газар нутгийн хэмжээ 82,287 км². Төсөл хэрэгжих Сүхбаатар сум нь Баянгол, Хайлаастай, Хулгар, Ланз, Шинэбулаг гэсэн 5 багтай. Асгат сум нь Өлзийт, Дөхөм, Их-Уул, Жаргалант гэсэн 4 багтай.

Хүн ам, өрхийн тоо: Төсөл хэрэгжих Ланз багийн хүн амын тоо нийт 530 байгаагаас эрэгтэй 307, эмэгтэй 223 байна.

2023-2024 онд шилжих өвөл манай орны ихэнх хэсгээр ялангуяа зүүн бүсийн нутгаар өвөлжилт хүндэрч зуд болсонтой холбоотойгоор олон айлын мал үрэгдэж малгүй болсон айлууд аймгийн төврүү шилжсэн байна.

Сүхбаатар аймгийн өрхийн тоо 2025 оны байдлаар нийт 19,700 ба үүнээс Сүхбаатар суманд 1,230 өрх, Ланз багт 189 өрх, Асгат сумын өрхийн тоо 617 байгаагаас Өлзийт багт 114 өрх амьдарч байна.

Хүн амын суурьшил дунд зэрэг, нэг кв.км талбайд 0.8 хүн суудаг. Өвлийн болон отор нүүдлийн үед бусад аймаг сумдын малчид ирж нутагладаг байна. Хүн амын гол хөдөлмөр нь мал аж ахуй (хонь, ямаа, үхэр, адуу, тэмээ).

Боловсролын түвшин өмнө жилүүдээс харьцангуй өссөн ба бичиг үсэг мэддэггүй хүн амын түвшин буурч. Арав тав ба түүнээс дээш насны хүн амын 95.7 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна.

Сүхбаатар аймгийн суурин хүн амын 14.1 хувь нь дээд ба түүнээс дээш боловсролтой. Сүхбаатар аймгийн ажилгүй иргэдийн дотор 30-44 насны 766 залуучууд нийт ажилгүй иргэдийн 42.4 хувийг эзэлж байна. Харин 30-аас дээш насныханд эрэгтэйчүүд илүү их ажилгүйдэлд өртөж байна. Харин Сүхбаатар сум нь Сүхбаатар аймгийн бусад сумуудаас ажилгүйдлийн түвшин харьцангуй бага байна.

Орон нутгийн төсвийн орлого: Сүхбаатар аймгийн төсвийн нийт орлого 2025 оны жилийн эцсийн байдлаар 103.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 20.5 (24.8%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 83.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 19.5 (30.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Аймгийн нийт төсвийн 41.0 хувийг орон нутгийн төсвийн орлого, 13.5 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 11.1 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 16.7 хувийг орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг, 15.9 хувийг урьд оны үлдэгдэл, 1.8 хувийг төсөвт байгууллагуудын өөрийн орлого тус тус эзэлж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хөрөнгө оруулалт 30.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 6.1 (16.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн тоо: Статистикийн бизнес регистр (СБР)-ийн санд 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,812 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдэж, өмнөх оноос 328 (22.1 %)-аар нэмэгдсэн байна. Хуулийн этгээдийн 932 (51.4 %) нь компани, 411 (22.7 %) нь бусад (ТБ, ТББ, бусад), 353 (19.5 %) нь хоршоо, 92 (5.1%) нь нөхөрлөл, 24 (1.3%) нь ТӨҮГ, ОНӨҮГ байна. Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй байгаа 1,812 хуулийн этгээдийн 50.4 хувь нь үйл ажиллагаа явуулж, 49.6 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн 535 (80.8 %) нь үйл ажиллагаа түр зогсоосон, 120 (18.1 %) нь үйл ажиллагаа эхлээгүй, 7 (1.1 %) нь үйл ажиллагаа бүрэн зогссон байна.

2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр бизнес регистрийн санд бүртгэлтэй 353 хоршоо бүртгэгдэж, өмнөх оноос 252 (3.5 дахин)-оор нэмэгдсэн байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй 353 хоршооны 118 (33.4 %) нь үйл ажиллагаа явуулж байна.

Малын тоо, төллөлт болон малтай өрх: Сүхбаатар сум болон Ланз багийн малын 2020-2024 оны байдлаар нийт тоог харахад 2022 он хүртэл эрчимтэй өсөж байсан бол 2023 онд Сүхбаатар сумын нийт мал 5.2 %-аар тэр дундаа Ланз багийн нийт малын тоо 11.3 %-аар цөөрсөн байна. 2024 онд Сүхбаатар сумын нийт малын тоо 65.5 %-аар цөөрч, Ланз багийн малын тоо 88.3 %-аар цөөрч олон өрх малгүй болсон байна.

Аж үйлдвэр: Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 285.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 59.3 (26.2 %) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт (28.3 %) тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрлэл 3.5 (12.8 %) тэрбум төгрөг, цахилгаан, дулаан эрчим хүчний үйлдвэрлэлт 3.8 (23.2 %) тэрбум төгрөг, усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 0.7 (42.2 %) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 232.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 51.2 (28.3 %) тэрбум төгрөгөөр өсөхөд чулуун болон хүрэн нүүрс олборлолт 13.7 (24.8 %) тэрбум

төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 21.9 (23.6 %) тэрбум төгрөг, бусад ашигт малтмал олборлолт 15.6 (47.0 %) тэрбум төгрөгөөр өссөн нь тус тус голлон нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдрийн баяжмал, хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал олборлолтын биет хэмжээ 10.1 хувиас 5.7 дахин өсжээ.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 4.2 (1.1 %) тэрбум төгрөгөөр буурахад металлын хүдрийн олборлолтын салбарын борлуулалт 54.7 (21.6 %) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Гадаад зах зээлд 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 385.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 365.6 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 32.8 хувийг нүүрс олборлолтын салбар, 54.3 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 12.8 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

Төслийн эдийн засгийн үр ашиг

Төслөөс улс, орон нутгийн төсөвт төвлөрөх орлого:

Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ашиглах уурхайг байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ 334.16 тэрбум төгрөг байна. Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 248,835.54 мян.м³ хөрс хуулалтын ажлыг хийж, 89,930.26 мян.тн нүүрсийг олборлоно. Нэг тн нүүрсийг 65,000 төгрөгөөр борлуулахаар тооцсон.

Төслийн эдийн засгийн үр ашиг:

Орд ашиглалтын 20 жилийн хугацаанд нийт 5,845.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 1,969.3 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 2,909.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Ашиглалтын хугацаанд нийт 3,211.7 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болно. 10 хувийн хорогдуулалтын норм тооцсон төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ 905.6 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 36% байна, хөрөнгө оруулалтаа 3.9 жилд нөхнө.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт зэргээс газрын хэвлийд ихээхэн хоосон орон зай үүсэх бөгөөд хөрсөн бүрхэвч, ургамал болон шавжуудын амьдрах орчныг өөрчилж ховор болон эндемик/унаган/ төрөл зүйлийг багасгах магадлалтай. Үйл ажиллагааны турш тээвэрлэлт явагдах тул талбайн ойр орчмын газрын гадаргыг тоос дарж хөрс, ургамал, орчныг бохирдуулна.

Хогийн цэгээс үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл: Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадаргад бохирдол үүснэ. Хэдийгээр дунд хугацаанд нөлөөлөл үзүүлэх боловч төслийн хугацаа дуусахад эргэн нөхөн сэргээгдэх боломжтой.

Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл: Замын хөдөлгөөн, хөрс хуулалт, нүүрс олборлолт, тээвэрлэлтээс үүдэлтэй агаарын тоосжилт, дизель түлшээр ажилладаг машин механизм тоног төхөөрөмж, саармагжсан нүүрсний өөрөө шаталтаас үүсэж болзошгүй хий утаа, дуу чимээ, хог хаягдлаас үүсэх үнэр зэрэг болно.

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл: Уурхайн унд-ахуйн усны хэрэгцээг гүний худгаас, зам, ногоон байгууламж усалгааг ил уурхайд шүүрэн орж ирэх шүүрлийн уснаас авч ашиглах бөгөөд энэ нь газрын доорх усны хомсдолд үүсгэж болзошгүй.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл: Ойролцоо орших олборлолтын талбай болон тэдгээр талбай руу шатах тослох материалын тээвэрлэлт, нүүрсний олборлолт зэргийн тээвэрлэлтээс шалтгаалсан техникийн олон салаа зам үүсэж тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах хөрсний гадаргад хуурай тоос шороон хучаас үүсгэх.

Машин техникийн олон салаа зам үүсэж талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулна. Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулж болзошгүй.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Ил уурхайн талбайд байсан ургамал устана. Уурхайд олон янзын зориулалтаар машин техник ашиглаж, тэдгээрээс үүдэн олон салаа зам үүсэж бий болох магадлалтай. Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадаргад шороо тоос үүсэж, улмаар салхи шуурганд хийсэн ойр орчмын ургамал бүрхэвч, төслийн талбай тоос шороонд дарагдаж болзошгүй. Байгууламжууд баригдах талбай нь төслийн хугацаанд хүний хөлөөр болон тээврийн хэрэгслээр талхлагдаж бүрэн өөрчлөлтөд орно. Тосгоноос ахуйн хог хаягдал их хэмжээгээр үүсэж, хадгалах зайлуулах стандарт, дүрэм, журам барьж ажиллаагүйгээс гадаргад бохирдол үүсэж болзошгүй. Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадарга болон ургамлан нөмрөгт бохирдол үүснэ. Тоосжилт үүссэнээс ойр орчмын ургамлууд дээр бууж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Олборлолт явуулахаас өмнө өнгөн хөрс хуулж овоолго хийсэн ба овоолго болон түүний орчмын талбайн амьтан /элдэв шавжийн бүлгэмдэл/, тэдгээрийн амьдрах орчин үгүй болох. Машин техникийн дуу чимээнээс зэрлэг амьтад үргэн дайжих.

Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Ажилчдын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдалт, үйлдвэрлэлийн ослоос

урьдчилан сэргийлж чадна. Уурхайн ажлын үед ажиллах хүнд машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүснэ.

Саармагжсан нүүрс өөрөө шатах эрсдэл: Нүүрсний өөрөө шаталт гэдэг нь дулааны гаднын эх үүсвэрийн оролцоогүйгээр явагдах исэлдэлтийн урвал юм. Энэхүү процесс нь температурыг нэмэгдүүлдэг материалын өөрийн дотоод дулааныг өөрчлөх үзэгдэл юм. Нөгөө талаас ил дөл үүсэж шатах үзэгдэл юм. Нүүрсний исэлдэх явцыг түргэсгэдэг гадаад нөлөөллийн тоонд агаарын чийг, тунадас, халуун хүйтний өөрчлөлт орно.

Уурхай дахь нүүрс шаталт, нүүрсний талбай дахь нүүрс шатах, саармагжсан нүүрс шатах гэдэг эрсдэл манай төслийн хувьд бодитоор бий болох магадлалтай байна.

Газрын гадарга дээр гаргасан нүүрсний шаталтаас сэргийлэх дараах зөвлөмжүүд байна. Үүнд:

- ✓ Бүтээгдэхүүн гаргалт болон борлуулалтын хэмжээг уялдуулж агуулах дахь нүүрсний хэмжээг аль болох хамгийн бага байлгах;
- ✓ Агуулахын талбайн улыг цэвэрлэх;
- ✓ Чийгийг хэмжих;
- ✓ Нүүрсний агуулахыг бусад барилга байгууламжаас хол бөгөөд гал дамжин авалцахгүй байх талаас төлөвлөх;
- ✓ Агуулахад галын булан, гал унтраах хэрэгслийг бэлэн байлгана;
- ✓ Уст үеэс олборлосон нүүрсийг тусад нь овоолж тэмдэглэн түрүүлж ачих бодлого баримтлах зэрэг болно.

Нүүрс өөрөө шатсан үед авах арга хэмжээ:

1. Шаталтын голомтыг илрүүлэх
 - Дулааны өсөлт, утааны үнэр, өнгө, нүүрсний овоолгын гадаргуугийн халалт зэргийг ажиглана.
 - Дулаан хэмжигч/термопар/, хий хэмжигч/ CO , CO_2 /, дулааны камер ашиглана.
2. Аюулгүй бүс тогтоох
 - Галын бүсийг нэн даруй тусгаарлан ойр орчмын хүний хөдөлгөөн, техник механизмын ажиллагааг зогсоох
3. Дулааныг багасгах ба хүчилтөрөгчийг хязгаарлах
 - Нүүрсний овоолгыг задалж дэлгэж хөргөх
 - Шатсан хэсгийг ус, хөөс, уураар цохих
 - Шороогоор хучиж хүчилтөрөгчийн урсгалыг багасгах зэрэг арга хэмжээг авах боломжтой.

БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБҮ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн

дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Одоогийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

- ✓ Төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
- ✓ Уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хамрах хүрээ;
- ✓ БОМТ-г хэрэгжүүлэх хүний нөөц, БО-ны удирдлагын бүтэц зохион байгуулалт;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө;

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

БОМТ-ний бүтэц: БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 7 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
7. Дүгнэлт

БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт № 6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	2026 он	Давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
1. УСАН ОРЧИН							
1	Тос тосолгооны материал, ШТМ хөрсөнд нэвчин газрын доорх ус бохирдох	Засварын хэсгийг хатуу хучилттай болгох, арчлах	Засварын хэсэг	мян.төг	1,500.0	2026 он	- Усны тухай хууль - MNS ISO 4064-2:2013 Битүү шугам хоолой дахь усны зарцуулалтын хэмжилт. Ундны хүйтэн ба халуун усны тоолуур. 2-р хэсэг Суурилуулахад тавих шаардлага
2	Усны нөөц хомсдох	Гүний худагт тоолуур тавих	Газрын доорх ус	мян.төг	500.0	2026 он	
2. ХӨРСӨН БҮРХЭВЧ							
1	Тээвэрлэлтийн явцад олон салаа зам үүсэх	Уурхайн замын тэмдэг тэмдэглэгээг засварлах, сайжруулах	Дотоод тээврийн зам	мян.төг	300.0	Жил бүр	- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль - MNS 4597:2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
3. АМЬТНЫ АЙМАГ							
1	Мал, амьтан ил уурхайн ухаш, далан шуудуу руу унаж эрсдэх	Хамгаалалтын хашаа барих, арчлах	Уурхайн ухаш	мян.төг	4,000.0	Жил бүр	- Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм
Нийт				мян.төг	6,300.0		

5.1.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ил аргаар ашиглах төсөл нь ордыг 20 жил ашиглахаар ТЭЗҮ батлуулсан байна. Ашиглалтын 21 дэх жилээс техникийн нөхөн сэргээлт хийгдэнэ. Биологийн нөхөн сэргээлтийн ажил уурхайн олборлолт бүрэн дууссаны дараа хийгдэхээр төлөвлөгдсөн. Иймд 2026 онд нөхөн сэргээлтийн ажил хийх боломжгүй гэж үзэн энэхүү тайланд нөхөн сэргээлтийн зардал тусгаагүй болно.

5.1.3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сүхбаатар аймгийн Байгаль орчны газраас Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хийх ажлын санал авсан бөгөөд Дорнын чулуулаг ХХК нь Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд төсөвт өртгөөр аймгийн Байгаль орчны газрын саналын дагуу ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт № 7 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба м давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	• Мэргэжлийн байгууллагаар Дарханхаан-Уул Дурсгалт газрын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын сонгон шалгаруулалт зохион байгуулна	Дарханхаан-Уул ДГ-ын БОМТ	1	26,598.15	202 6 он	Сүхбаатар аймгийн Байгаль орчны газрын даргын 2025 оны 3-р сарын 14-ний 60 тоот албан санал
Нийт				26,598.15		

5.1.4. ТЭРБУМ МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ТАРИХ МОДНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Дорнын чулуулаг” ХХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд жил бүр 1,000 ш модыг /1 суулгац өртөг-20,000 төгрөг/ орон нутагтай зөвшилцөж Сүхбаатар аймгийн Байгаль орчны газраас санал болгосон газарт буюу Асгат сумын төвд тарина.

Хүснэгт № 8 Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөөний зардал

№	Хийгдэх ажил	Тарих модны тоо /ш/	Хэмжих нэгж	2026
1	2	3	4	5
1	Сүхбаатар аймгийн БОГ-аас ирсэн саналын хүрээнд төсөвт өртгөөр хамтран ажиллана	1,000	мян.төг	20,000.0
Нийт				20,000.0

5.1.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн төлөвлөлтөөр уурхайн үйл ажиллагааны үед нөлөөлөлд өртөх айл 3 байгаа бөгөөд төслийн ТЭЗҮ-ийн төлөвлөлтөөр 10 дахь жилээс уурхайн тэлэлтээс хамааран нүүлгэн шилжүүлэх шаардлага үүснэ. Иймд энэ удаагийн БОННУ-нд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгаагүй болно.

2026 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөөгүй болно.

5.1.6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Дорнын чулуулаг” ХХК нь 2012 онд Монгол улсын Шинжлэх ухааны академи палеонтологийн төвөөр палеонтологийн хайгуул судалгааны ажлыг Сүхбаатар аймгийн Сүхбаатар болон Асгат сумдын нутагт орших Ерөөлт нэртэй хайгуулын 15,309.06 га талбайд, Цагаан залаат нэртэй 10,098.09 га талбайд тус тус гэрээгээр хийж гүйцэтгүүлсэн байна. Палеонтологийн судалгаа, ажиглалтын үр дүнд Ерөөлт болон Цагаан залаат нэртэй 2 талбайд эртний амьтан, ургамлын үлдэгдэл илрээгүй байна. Харин хайгуул, судалгаа хийсэн эхний талбайд 3 хэсэг газарт дурсгалууд илэрсэн байна. Тэдгээр нь Дорнын чулуулаг ХХК-ийн MV-017433 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас гадна байх бөгөөд хамгийн ойрдоо 1.5 км зайтай байна. Судалгаа хийсэн 2 дахь талбайд 4 хэсэг газарт дурсгалууд илэрсэн байна. Тэдгээр нь MV-017432 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас гадна байна. Тусгай зөвшөөрлийн хилээс хамгийн ойрхон нь шулуунаар 4.5 км зайд байна. Эдгээр дурсгалууд нь монгол булш, дөрвөлжин булш болон цаг хугацаа, нэр тодорхойгүй булшнууд байна.

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд эдгээр дурсгалуудыг тэмдэгжүүлэх ажлыг хийхээр төлөвлөлөө.

Хүснэгт № 9 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	2026
1	Хайгуул судалгаагаар илэрсэн дурсгалуудыг тэмдэгжүүлэх	мян.төг	300.0

Цаашид “Дорнын чулуулаг” ХХК нь уурхайн ашиглалтын явцад хэрэв хүн малын яс, шавар ваар савны хагархай, янз бүрийн хүрэл, төмөр эдлэл, түүний хэлтэрхий, хугархай гэх мэт хүний гараар хийсэн ямар нэг эд өлгийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд орон нутгийн удирдлага, БО-ны хяналтын улсын байцаагч, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж хамгаалалтад авах ба дурдсан мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж малтлага судалгаа хийлгэх шаардлагатай. Мөн биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцыг мөрдлөг болгон уурхай орчмын дурсгалт газрууд, өнгөрсөн үеийн хүн төрөлхтний түүхийн дурсгалууд, биет бус соёлын өв болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янз байдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, хамгаалах чиглэлээр ажиллах ба энэ талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн БОМТ-д тусган хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

5.1.7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 10 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7
1	Гэнэтийн гал түймрийн аюулын үед үүсэх эрсдэл	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгсэл, галын аюулын тухай самбар, тэмдэг, тэмдэглэгээг зохих газруудад байрлуулах	Уурхайн барилга байгууламж болон ил уурхай орчимд	5,000.0	Тухайн жилдээ	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр

	Мананцар үүсгэгч, нүүрсний чийг хэмжигч авах				томьёо, тодорхойлолт, ерөнхий анги -MNS ILO OSH 1:2003, “ХАБЭА- н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж” -Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагатай хамтран уурхайн ажилчдын дунд сургалт зохион байгуулах	Ажилчид	1,000.0	Тухайн жилдээ	
Нийт			6,000.0		

5.1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Дорнын чулуулаг” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хүснэгт № 11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал
1	2	3	4	5	6
1	Хатуу хог хаягдлын цэгийг битүүмжлэлтэй байгуулах, хашаалах	Хогийн цэг	2,000.0	2026 он	Хог хаягдлын тухай хууль
2	Аюултай хог хаягдлыг хадгалах хэсгийг тохижуулах, тэмдэглэгээ хийх, гэрээ байгуулан ачуулж зайлуулах	Хэрэглэсэн батареи, ажилсан тос, ШТМ гэх мэт	3,000.0	2026 он	
3	Ахуйн хог хаягдлаа орон нутагтай гэрээ байгуулан тээвэрлүүлэх	Ахуйн хатуу хог хаягдал	1,200.0	Сар бүр	
Нийт			6,200.0		

5.1.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн А/642 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орчны чанарын хяналт шинжилгээний ажил, үйлчилгээний хөлс, үнэ тариф”-ыг үндэслэн тооцов.


Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат сумдын нутаг дэвсгэрт “Ерөөлтийн хүрэн нүүрсний орд”-ыг олборлохоор “Дорнын чулуулаг” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа болон үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөлөл байдлын үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. ОХШХ нь БОХТ-тэйгөө нягт уялдсан байх бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний

үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Дорнын чулуулаг” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 сард холбогдох сум, аймаг, төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Дорнын чулуулаг” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

Хүснэгт № 12 ОХИХ-ийн мониторингийн цэгүүдийн координат

№	Шинжилгээ авах төрөл	Мониторингийн цэг	
1	Агаарын сорьц шинжилгээ /PM2.5, PM10, TSP, дэгдэмхий органик нэгдэл, шуугианы түвшин тодорхойлох хэмжилт/	113° 59' 18.55"	46° 24' 09.19"
2		114° 01' 20.64"	46° 24' 02.98"
3		114° 00' 33.84"	46° 23' 15.48"
4		114° 01' 06.00"	46° 24' 15.00"
5	Хөрсний задлан шинжилгээ /агрохими, хүнд металл, эрүүл ахуй/	113° 59' 14.38"	46° 24' 00.21"
6		113° 59' 41.67"	46° 23' 36.91"
7		114° 00' 02.90"	46° 24' 18.30"
8		113° 59' 18.55"	46° 24' 09.19"
9	Усны ерөнхий химийн шинжилгээ	114° 00' 02.90"	46° 24' 18.30"
10	Шүүрлийн усны шинжилгээ	114° 00' 10.45"	46° 23' 17.94"
11	Ургамлын мониторинг судалгаа	113° 56' 28.27"	46° 24' 52.81"
12		113° 56' 13.08"	46° 23' 19.52"
13		113° 54' 46.30"	46° 21' 22.03"
14		113° 59' 23.73"	46° 24' 12.44"
15		113° 59' 44.14"	46° 23' 42.58"
16		113° 59' 44.48"	46° 23' 10.40"
17		114° 01' 17.73"	46° 23' 32.78"
18	Цацрагийн шинжилгээ	Нүүрснээс	



Зураг № 3 ОХШХ-ийн мониторингийн цэгүүд

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж, жил	2026 он	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7
1. Агаарын чанар						
1	(PM10, PM2.5, SO ₂ , NO ₂ , CO)	Ил уурхай, зам, овоолго	3	Жилд 2 удаа 5, 9-р саруудад	300.0	-MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Дуу шуугиан	Ил уурхай, зам, ажилчдын хотхон	3		90.0	- MNS 6063:2010 Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх
3	Дэгдэмхий органик нэгдэл	Ил уурхай, овоолго, зам	3		60.0	бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ
2. Хөрсний чанар						
1	Агрохими	Ил уурхай орчимд, ажилчдын хотхон, зам	3	Жилд 2 удаа 5, 9-р саруудад	210.0	-MNS 3985: 87. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл
2	Хүнд металл	Ил уурхай, Овоолго, засварын газар	3		150.0	-MNS 3310:91. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
3	Эрүүл ахуй	Хогийн цэг, ариун цэврийн байгууламж, ажилчдын хотхон	3		80.0	
3. Усны чанар						
1	Усны ерөнхий үзүүлэлтүүд, Микробиологийн шинжилгээ	Гүний худаг	1	Жилд 2 удаа 5, 9-р саруудад	80.0	- MNS 0900:2018. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх
2	Усны ерөнхий үзүүлэлтүүд, хүнд металл, шүүрлийн усны шинжилгээ	Шүүрлийн ус	1	Жил бүрийн 6-р сард	99.0	- MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага.
4. Ургамлан нөмрөг						
1	Ургамлын мониторинг	Жил бүрийн УАТ-гөөр нэмж эвдэгдэх талбайд ховор ургамлын тархцын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэн арга хэмжээг төлөвлөх	7	Жил бүрийн 7-р сард	3,000.0	MNS 2967:1980 Чихэр өвсний тариалах үр
5. Физик нөлөөлөл						
1	Цацрагийн шинжилгээ	Нүүрс	1	Жил бүр	100.0	- MNS 5072:2001 Барилгын материал, хөрс, уулын чулуулагт цацраг идэвхт элемент тодорхойлох гамма спектрометрийн арга - MNS 5626:2006 Цацрагийн хамгаалалт. Лабораторийн гамма спектрометрийн арга

Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат сумдын нутагт хэрэгжиж буй
Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ил аргаар
ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж, жил	2026 он	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7
Нийт					4,239.0	

5.1.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт № 14 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6
1	Ажилчдад ХАБЭА-н талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	ХАБЭА удирдлага	500.0	Жил бүр	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай
2	БОХ талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	БО-ы ажилтан, Уурхайн дарга	500.0	Жил бүр	
Нийт			1,000.0		

5.1.11. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт № 15 БОМТ-ний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7
1	БИНХ буюу нөлөөллийн бүсийн айлуудад	Уулзалт, санал асуулга, танилцуулга хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	11-р сард	Тайлагнах	Ланз, Өлзийт БИНХ
2	БОУАӨЯ	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	Тайлагнах	БОУАӨЯ
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Цаашид анхаарах асуудал	Засаг даргын тамгын газар

5.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

Хүснэгт № 16 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	х.нэгж	2026 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	6,300.0
2	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөө	мян.төг	20,000.0
3	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	26,598.15

Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат сумдын нутагт хэрэгжиж буй
 Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ил аргаар
 ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	мян.төг	6,000.0
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	мян.төг	300.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	мян.төг	6,200.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	мян.төг	4,239.0
8	Тухайн жилийн удирдлага зохион байгуулалт	мян.төг	1,000.0
Нийт		мян.төг	50,637.15

*Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд жил бүрийн тарих модны тоо болон зардлыг БОМТ төлөвлөгөөнд тусгаж төлөвлөж өгсөн. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар 04-ний өдрийн 58 дугаар зарлигийн 2-т зааснаар Тэрбум мод үндэсний хөдөлгөөн нь иргэн аж ахуй нэгжийг мод тарихыг уриалсан сайн дурын ажил тул БОМТ-ний нийт төлөвлөгдсөн зардалд тусгаагүй болно.

Цагаан залаатын уурхайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд 2026 онд 50,637.15 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөлөө.

ДҮГНЭЛТ

Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат сумдын нутагт орших Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ил аргаар ашиглах төсөлд Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Ашигт малтмалын тухай хууль”, “Газрын хэвлийн тухай хууль”, “Байгалийн нөөцийг ашиглах тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” зэрэг хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжуудад тулгуурлан байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлээ.

“Дорнын чулуулаг” ХХК-ний байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараах дүгнэлтэд хүрлээ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон цаг хугацаанд нь хэрэгжүүлэх шаардлагатай.

Барилгын чулууны ордын үйл ажиллагааны явцад хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд орох учир нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд 2026 онд 50,637.15 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөвөө. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.10 -т зааснаар төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, Монгол улсын холбогдох хууль тогтоомжууд болон олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, байгаль орчинд халгүй үйл ажиллагаа явуулах үр ашгийг тогтмол дээшлүүлэх, шинэ дэвшилтэт технологийг хөгжүүлэн нэвтрүүлэхэд зарцуулах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгож, нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 %-ийг БОУАӨЯ-ны төсөвт байршуулах шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат сумдын нутагт орших Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1, УБ, 2025 он
2. Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Асгат сумдын нутагт орших Ерөөлтийн хүрэн нүүрсний ордын Цагаан залаатын хэсгийг ил аргаар ашиглах төслийн “Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан” УБ, 2026 он
3. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
6. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхэтгэл УБ 2010.
7. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын А/618 тоот тушаал, 2019 он
8. “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” Засгийн газрын 58-р тогтоол, 2023 он
9. Байгаль орчны сайдын тушаал: 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаал, Байгаль орчны үнэлгээний аргачилсан заавар.
10. <http://www.legalinfo.mn>